



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 633

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2022 оны 07/04 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн өмчөөс шилжүүлсэн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4 нэрийн нийт 263,001,861.00 (хоёр зуун жаран гурван сая нэг мянга найман зуун жаран нэгэн) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасны дагуу төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн Дорноговь аймаг дахь салбарын дарга Д.Чинтогтох, Говьсүмбэр салбарын дарга Б.Баттуул, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мөнх-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 12 дугаар сарын .....-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт



**Төрийн өмчид бүртгэх, хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
<b>"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн Говьсүмбэр салбарт бүртгэх хөрөнгийн жагсаалт</b>						
1	Мянган хороололд 0.4 кВт цахилгааны шугам /Айраг сум/	2020	м	700	40,000,000.00	40,000,000.00
2	Цахилгаан хангамжийн шугам татах 10 кВ 10/0.4 кВ-ын 160 кВа /Айраг/	2019	м	1100	51,627,080.00	51,627,080.00
3	Цомог багийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж /Даланжаргалан сум/	2020	м	900	112,702,592.00	112,702,592.00
<b>Хэсгийн дүн</b>				2700	<b>204,329,672.00</b>	<b>204,329,672.00</b>
<b>"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн Дорноговь аймаг дахь салбарт бүртгэх хөрөнгийн жагсаалт</b>						
4	Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /Дэлгэрэх сум/	2021	м	1600	58,672,189.00	58,672,189.00
<b>Хэсгийн дүн</b>				1600	<b>58,672,189.00</b>	<b>58,672,189.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>				<b>4300</b>		<b>263,001,861.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>						<b>(хоёр зуун жаран гурван сая нэг мянга найман зуун жаран нэг)</b>